



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон. 206, 207, 210, 213 тоот
7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

᠒᠐23.02.26 № 02/154
танай _____ -ны № _____ -т

**ЛУУС СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.ЖУГДЭРСҮРЭН ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Луус сумын Соёлын төвийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийлээ.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн нөхөн төлүүлэх төлбөрийн акт, зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлж байна.

Төлбөрийн актыг барагдуулан, албан шаардлагыг хэрэгжүүлж, заасан хугацаанд хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт хуудас

ДАРГА



Р.МӨНХТОГТОХ

᠐᠐12032622


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 204

A/1270320

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Луус сумын Соёлын төвийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийлээ.

Аудитаар төрийн өмчийг бусад хуулийн этгээдэд үнэ төлбөргүй ашиглуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27.1-т /Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр тор, хувийн хэвшлийн түшиглэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно/, 28.5-д /Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна/, Төсвийн тухай хуулийн 16.5.4-т /Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.3-т заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бусдад үнэгүй ашиглуулсан төрийн хөрөнгийг түрээсийн гэрээ байгуулан эзэмшүүлж, төлбөрийг холбогдох журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Луус сумын Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Жүгдэрсүрэн, нягтлан бодогч Э.Сумъяажаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Ж.УГТАХБАЯР

БАТАЛГААЖУУДСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

0012042003


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 88

А/1271320

Мандалговь

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Луус сумын Соёлын төвийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийлээ.

Аудитаар ажлаас гарсан албан хаагчид олгосон 300,000.00 /Гурван зуун мянга/ төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй, зардлаар тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д /төсвийг зохистой удирдаж авлага, ор төлбөр үүсгэхгүй байх/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т /Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажлаас гарсан албан хаагчид илүү олгосон 300,000.00 /Гурван зуун мянга/ төгрөгийн цалингийн урьдчилгааг нөхөн гаргуулж Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн **100080000955** дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Цаашид ажлаас гарч байгаа албан хаагчтай холбогдох тооцоог хийж, өглөг, авлагагүй ажиллаж хэвших;
3. Актын биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

0012050441

Дундговь аймгийн Луус сумын Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
М.Жигжидсүрэн, нягтлан бодогч Э.Сумьяажаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР




Ж.УГТАХБАЯР

БАТАЛГААЖУУЛСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



МӨНХТОГТОХ




**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 87 А/127 03 20

Мандалговь

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Луус сумын Соёлын төвийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийлээ.

Аудитаар үндсэн хөрөнгийн данснаас дутагдсан 280,000.00 /Хоёр зуун наян мянга/ төгрөгийн үнэ бүхий морин хуурыг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, холбогдох арга хэмжээ аваагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.1.4 /үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ/, 73.2 /Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-г /Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.7-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үндсэн хөрөнгийн данснаас дутагдсан 280,000.00 /Хоёр зуун наян мянга/ төгрөгийн үнэ бүхий морин хуурыг буруутай этгээдээр нөхөн төлүүлж Дундговь аймгийн Луус сумын Соёлын төвийн Төрийн сан банк дахь **100081035095** дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Цаашид хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар ажил зохион байгуулах;
3. Актын биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын орлон. Утас: 70593113

0012050445

Дундговь аймгийн Луус сумын Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
М.Жигжидсүрэн, нягтлан бодогч Э.Сумъяажаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:


АУДИТОР



Ж.УГТАХБАЯР

БАТАЛГААЖУУЛСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



МӨНХТОГТОХ




**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 206

А/М 8 0320

Мандалговь

Зорчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Луус сумын Соёлын төвийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд заверын аудит хийлээ. Аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Дутагдсан 150,000.00 *нэг зуун тавин мянга* төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг нөхөн төлүүлсэн ч бүртгэлээс хасаагүй, үлдэгдлээр тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т *халбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*, 20.2.6-д *Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах* заасныг тус тус зөрчсөн байна.

2. Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 4 нэр төрлийн түүх соёл, музейн дурсгалт зүйлс дутагдсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д *дансны оглог, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйцээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*, 20.2.6-д *Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах* заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зорчсон, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зорчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.2-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дутагдсан 150,000.00 *нэг зуун тавин мянга* төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврын дагуу бүртгэлээс хасах;
2. Хулгайд алдагдсан 4 нэр төрлийн түүх соёл, музейн дурсгалт зүйлсийг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах;

8012042001

3. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Луус сумын Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Жүгдэрсүрэн, нягтлан бодогч Э.Сумъяажаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Ж.УГТАХБАЯР

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

ААБ 5.2: АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛГЭЙ АСУУДЛЫГ ҮНЭЛЖ, ШИЙДВЭРЛЭХ

Байгууллагын нэр: ЛУУС СУМЫН СОЁЛЫН ТӨВ
Тайланг хугацаа: 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Асуудлыг шийдвэрлэхэд үндэслэл болгосон | | Асуудлыг шийдвэрлэсэн байдал | | | Гаргасан шийдэл |
|---|--|---|------------|---|----------------------------------|------------------------------|---|-----------------------|-------------------------|
| | | | | Холбогдох хууль тогтоомжийн нэр, заалт | Холбогдох стандартын нэр, заалт | Аудиторын санал | Аудитыг хянан удирдах ажилтнуудын санал | Менежер | |
| 1 | Зардлын данстай холбоотой асуудал | Ажлаас гарсан албан хаагчид олгосон цалингийн урьдчилгааг суутгаагүй, авлагаар тайлагнаагүй. | 300,000.00 | Төсвийн тухай хуулийн 6.4.8-д /төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/, Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйцээж гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр, тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ | Сангийн сайдын 388 дугаар тушаал | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоосон |
| 2 | Хөрөнгийн данстай холбоотой асуудал | Үндсэн хөрөнгийн данснаас дутагдсан морин хуурыг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, холбогдох арга хэмжээ аваагүй. | 280,000.00 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.1.4 /үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдах, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгуулагад шилжүүлнэ /, 73.2 /Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана/ | Сангийн сайдын 388 дугаар тушаал | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоосон |

| | | | | | | | | |
|---|-------------------------------------|---|--------------|---|----------------------------------|--------------------------------------|--------------------------------------|---------------------------------------|
| 3 | Хөрөнгийн данстай холбоотой асуудал | Дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлсэн ч бүртгэлээ хасаагүй, үлдэгдлээр тайлагнасан. | 150,000.00 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах! | Сангийн сайдын 388 дугаар тушаал | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн |
| 4 | Хөрөнгийн данстай холбоотой асуудал | Төрийн өмчийг бусад хуулийн этгээлд үнэ төлбөргүй ашиглуулсан. | - | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27.1-т /Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашигуулж болно/, 28.5-д /Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үчийн төлбөрт үл хамаарна/, Төсвийн тухай хуулийн 16.5.4-т /Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх! | Сангийн сайдын 388 дугаар тушаал | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн |
| 5 | Зардлын данстай холбоотой асуудал | Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг илүү тайлагнасан. | 580,000.00 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-г /Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах! | Сангийн сайдын 388 дугаар тушаал | Санхүүгийн тайланд заруулах | Санхүүгийн тайланд заруулах | Санхүүгийн тайланд заруулсан |
| 6 | Хөрөнгийн данстай холбоотой асуудал | Нийт 4 нэр төрлийн түүх соёл, музейн дурсгалт зүйлс дутагдсан | - | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /Оансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, зүйлсээг гархаас нь өмнө хянан, баталгаажуулах/, 20.2.6-д /Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах! | Сангийн сайдын 388 дугаар тушаал | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн |
| | | | 1,310,000.00 | | | | | |

Нийт дүн

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.УГТАХБЯАР

Х.НАРАНЦАЙРАЛ

Р.МӨНХТОГТОХ

ААН 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: ЛУУС СУМЫН СОЁЛЫН ТӨВ
Тайлант хугацаа: 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

| № | Ажил гүйцээний ангилал, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний | |
|---|--|---|------------|---------------------------------------|---|--|---|---|----------------------------------|
| | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| A | I | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Зардлын данстай холбоотой асуудал | Ажлаас гарсан албан хаагчид олгосон цалингийн урьдчилгааг суутгаагүй, авлагаар тайлагнаагүй. | 300,000.00 | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн актыг 2023.12.20-ны дотор барагдуулахаар тохиролцов. | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоосон | Дарга, Нягтлан бодогч | М.Жүглэрсүрэн, Э.Сумъяажаргал |
| 2 | Хөрөнгийн данстай холбоотой асуудал | Үндсэн хөрөнгийн данснаас дутагдсан морин хуурыг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, холбогдох арга хэмжээ аваагүй. | 280,000.00 | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн актыг 2023.12.20-ны дотор барагдуулахаар тохиролцов. | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоосон | Дарга, Нягтлан бодогч | М.Жүглэрсүрэн, Э.Сумъяажаргал |
| 3 | Хөрөнгийн данстай холбоотой асуудал | Дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлсэн ч бүртгэлээс хасаагүй, үлдэгдлээр тайлагнасан. | 150,000.00 | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | 2023.09.19-ний өдөр асуудлын бүртгэлийг танилцуулснаар зөвшөөрсөн | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | Хугацаатай албан шаардлага шаардлага хүргүүлсэн | Дарга, Нягтлан бодогч | М.Жүглэрсүрэн, Э.Сумъяажаргал |
| 4 | Хөрөнгийн данстай холбоотой асуудал | Төрийн өмчийг бусад хуулийн этгээдэд үнэ төлбөргүй ашиглуулсан. | - | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | 2023.09.19-ний өдөр асуудлын бүртгэлийг танилцуулснаар зөвшөөрсөн | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн | Дарга, Нягтлан бодогч | М.Жүглэрсүрэн, Э.Сумъяажаргал |
| 5 | Зардлын данстай холбоотой асуудал | Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг илүү тайлагнасан. | 580,000.00 | Санхүүгийн тайланд залруулах | 2023.09.19-ний өдөр асуудлын бүртгэлийг танилцуулснаар зөвшөөрсөн | Санхүүгийн тайланд залруулах | Санхүүгийн тайланд залруулсан | Дарга, Нягтлан бодогч | М.Жүглэрсүрэн, Э.Сумъяажаргал |

| | | | | | | | | |
|-----------------|-------------------------------------|---|---------------------|--------------------------------------|---|---------------------------------------|-----------------------|----------------------------------|
| 6 | Хөрөнгийн данстай холбоотой асуудал | Нийт 4 нэр төрлийн түүх соёл, музейн дурсгалт зүйлс дутагдсан | | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | 2023.09.19-ний өдөр асуудлын бүртгэлийг танилцуулснаар зөвшөөрсөн | Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн | Дарга, Нягтлан бодогч | М.Жүгдэрсүрэн, Э.Сумъяажаргал |
| Нийт дүн | | | 1,310,000.00 | | | | | |

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.УГТАХБАЯР

Х.НАРАНЦАЦРАЛ

Р.МӨНХТОГТОХ

ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ

М.ЖҮГДЭСҮРЭН

Э.СУМЬАЖАРГАЛ

